



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 289

Улаанбаатар хот

Эрх бүхий албан тушаалтныг томилохыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2, Хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мандал даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр Чулуун овогтой Ванчин-Эрдэнэ, Батсайхан овогтой Жавхлан, хараат бус гишүүнээр Жамсрандорж овогтой Дэлгэрсайхан, нарийн бичгийн даргаар Балдан овогтой Энхтүвшин нарыг томилохыг зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороон даргын 2017 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 308 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, даатгуулагчдын хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн ажиллахыг Ч.Ванчин-Эрдэнэ, Б.Жавхлан, Ж.Дэлгэрсайхан, Б.Энхтүвшин нарт үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН